

ᠤᠪᠰ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠭᠳᠢᠲᠤᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид
нэг сая ба түүнээс дээс төгрөгийн хандив
өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн
хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

Орон нутгийн 2023 оны нөхөн болон
дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр
дэвшигчийн сонгуулийн зардлыг тайланг
хянаж, нийтэд мэдээлэх.

АУДИТЫН КОД:УВА-2023/51-15-ШТА-НА

УЛААНГОМ ХОТ
2023 ОН

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитын нэр:

Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээллээ.

Аудитын зорилго:

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад нөхөн сонгуульд оролцсон бие даан нэр дэвшигчийн ирүүлсэн тайлбар, арилжааны банкны ирүүлсэн нэр дэвшигчийн сонгуулийн данстай холбоотой тодорхойлолт, аймгийн ЗДТГ болон сумдын ИТХ-аас ирсэн албан бичиг зэрэг шаардлагатай эх сурвалжийг хамруулсан.

Арга зүй:

Аудитын ажлыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг үндэслэн бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн тайлбарыг хянаж, аймгийн ЗДТГ, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, арилжааны банкуудаас ирүүлсэн лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Үндсэн мэдээлэл:

Увс аймгийн Давст сумын 2-р багийн 1 тойрог, Түргэн сумын 2-р багийн 1 тойрогт тус тус явуулах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн өдрийг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байхаар товлон зарласан байна.

Түргэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нам, эвсэл, бие даан нэр дэвшигч оролцоогүй байна. Давст сумын Иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нам, эвсэл оролцоогүй ба 1 бие даан нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

/Хүснэгт 1/

Бие даан нэр дэвшигчийн нэр	Нам	Нэр дэвшигчид
С.Гунгаажанцан	0	1
Нийт	0	1

Эх сурвалж: /Аймгийн сонгуулийн хороо/

Харин Түргэн сумын нөхөн сонгуульд нэр дэвшигч бүртгүүлээгүйгээс сонгууль зохион байгуулагдаагүй байна.

БҮЛЭГ: 1. Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд нам, эвсэл оролцоогүй, сонгуульд оролцсон 1 бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгээгүй, зардал гаргаагүй байна.

1.1 Нөхөн сонгуульд оролцсон 1 бие даан нэр дэвшигч зардлын данс нээлгээгүй учраас Төрийн аудитын байгууллагад зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасан ч нөхөн сонгуульд нэр дэвшигч С.Гунгаажанцан нь сонгуулийн зардлын данс нээлгээгүй тул сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

1.2 Увс аймгийн Давст суманд үйл ажиллагаа явуулж буй Хаан банк, Төрийн банк Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56.5-д заасан үүргээ хэрэгжүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу Увс аймгийн Давст суманд үйл ажиллагаа явуулж буй Хаан банк, Төрийн банкууд хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж сонгуулийн зардлын нээгээгүй тухай тодорхойлолтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

1.3 Нөхөн сонгуульд оролцсон 1 бие даан нэр дэвшигч зардал гаргаагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу хуулийн хугацаанд 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээгээгүй, зардалд гаргаагүй гэсэн тайлбараа Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Давст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 1 бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгээгүй тул дансны дугаар, банкны нэрийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.
2. Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б.АВИРМЭД
Б.ОДГЭРЭЛ